



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Нийгмийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

П.Анужин

-Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга


Ажлын хэсгийн гишүүн:

Б.Жаргалмаа
М.Оюунчимэг
Д.Сарангэрэл
Ж.Чинбүрэн

-Улсын Их Хурлын гишүүн
-Улсын Их Хурлын гишүүн
-Улсын Их Хурлын гишүүн
-Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг оролцуулж ажиллуулахыг ажлын хэсэг (П.Анужин)-т зөвшөөрсүгэй.

НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



П.АНУЖИН